

АГУУЛГА

- 1. ӨМНӨХ ҮГ**
- 2. ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН МЭДЭГДЭЛ**
- 3. СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД**
 - 3.1. Алсын хараа
 - 3.2. Эрхэм зорилго, эрхэмлэн дээдлэх зүйлс, баримтлах зарчим
 - 3.3. Орчны шинжилгээ
 - 3.4. Стратегийн зорилт
 - 3.5. Үйл ажиллагааны хамрах хүрээ
 - 3.6. Стратегийн зорилт, бүтээгдэхүүний ангийн хоорондын уялдаа
- 4. ТУХАЙН ТӨСВИЙН ЖИЛД НИЙЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
 - 4.1. Тухайн төсвийн жилд нийлүүлэх арга хэмжээ
 - 4.2. Арга хэмжээг нийлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ
 - 4.3. Байгууллагын бүтэц зохион байгуулалт
 - 4.4. Санхүүгийн хяналт
 - 4.5. Байгууллагын үйл ажиллагааны хяналт
 - 4.6. Удирдлагын зүгээс шийдвэр гаргах үйл явцад тавих хяналт
- 5. ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**
 - 5.1. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэл
 - 5.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба төсвийн таамаглалын талаарх мэдэгдэл
 - 5.3. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
- 6. ӨМЧЛӨЛИЙН БУСАД ЗОРИЛТУУД**
 - 6.1. Өмчлөлийн зорилт
 - 6.2. Санхүүгийн үйл ажиллагааны зорилт ба үзүүлэлтүүд
 - 6.3. Эрсдэл
 - 6.4. Хууль эрхийн актын үйлчлэлтэй холбоотой эрсдэл
 - 6.5. Өмчлөлийн өөрчлөлт
 - 6.6. Бодлогын өөрчлөлт
- 7. ХАВСРАЛТУУД**
 - 7.1. Биеийн тамир, спортын газрын 2018 оны хүн өдрийн тооцоо

ӨМНӨХ ҮГ

Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын чухал нэгэн хэсэг нь төсвийн байгууллагын хэтийн төлөвлөлт юм. Санхүү эдийн засгийн сайдын 2003 оны 93 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулах заавар журмын дагуу байгууллагын ирэх дөрвөн жилийн төлөвлөлтийг боловсрууллаа. Энэхүү төлөвлөлтөд дараах зүйлүүдийг төлөвлөсөн болно.

Байгууллагын алсын хараа

Байгууллагын эрхэм зорилго

Стратегийн зорилтууд

Стратегийн зорилтыг ханган биелүүлэхэд чиглэгдсэн ажил үйлчилгээ

Өмчлөлийн зорилтууд

2016-2020 онд аймгийн Засаг даргад нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл тоо хэмжээ, шалгуур үзүүлэлт, өртөг зардлын хамт

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу жилийн эцсийн тайлангийн ижил үзүүлэлтээр боловсруулсан төсөв буюу төсөвлөсөн баланс

Ерөнхий менежерээс байгууллагын эд хөрөнгийг зүй зохистой зарцуулах, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар өмчлөлийн эрхтэй холбоотой зорилтууд тусгагдсан болно.

Энэхүү төлөвлөгөө нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хангахад чиглэгдсэн бодлогын баримт бичиг тул түүний үнэт чанар нь төрийн албан хаагчдын өдөр тутмын ажилд шууд мэдрэгдэхээсээ илүү зөв бодлого, хандлага чиглэл, сэтгэлгээ, удирдлага, арга барил үр дүнг бий болгох замаар үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг илүү үр дүнтэй ханган биелүүлэх боломжтой юм.

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН МЭДЭГДЭЛ

Биеийн тамир, спортын газрын дарга миний бие байгууллагынхаа үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан танилцуулж байна. Энэхүү төлөвлөгөөг боловсруулан Биеийн тамир, спортын газрын алсын хараа, хүрэх ирээдүй, түүнд хүрэх зам, үр дүнг тодорхойлсон болно.

Төлөвлөгөөнд тусгагдсан дунд хугацааны зорилго, зорилтыг хангахад гүйцэтгэх хэмжээ нь Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааг сайжруулах болон аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд орсон хийх ажлын төлөвлөгөө мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг биелүүлэхэд чиглэгдэх юм.

Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд боловсон хүчний мэдлэг ур чадварыг сайжруулан тэднийг бие дааж бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, стандартаар тайлагнах үйл ажиллагаанд анхаарч ажиллахын зэрэгцээ боловсон хүчнийг шилж сонгох, сургаж бэлтгэхэд онцгой анхаарч ажиллан удирдлагын манлайлыг хангаж, иргэдэд Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд чанартай гүйцэтгэж хүргэх, үйл ажиллагааны ил тод нээлттэй байх зарчмыг баримталж ажиллана.

Ажилтнуудын ажиллах ур чадвар тэдний хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх нэг гол үндэс нь ажиллах ая тухтай нөхцөл, сэтгэл ханамжийн баталгаа, хамт олны бүтээлч нэгдмэл сэтгэлгээг төлөвшүүлэн хэрэгжүүлэхийг чухалд үзнэ.

ДУНДГОВЬ АМЙГИЙН

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

М.НАРАНБАДРАХ

ГУРАВ. СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

3.1. АЛСЫН ХАРАА:

Аймгийн Биеийн тамир, спортын газар нь нийгэм улс төр, спортын салбарын үйл ажиллагаанд зохион байгуулалттай оролцох болон хөгжлийн бүх хэрэгцээг нь урамшуулан дэмжсэн салбарын хөгжил нийгмийн оролцоог хангасан орчин бүрдүүлнэ.

3.2. ЭРХЭМ ЗОРИЛГО:

ИРГЭДЭД: Нээлттэй ил тод, түргэн шуурхай, хүнд сурталгүй авлигаас ангид төрийн үйлчилгээг хүргэж ажиллана.

ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭХ ЗҮЙЛС:

Мэргэшсэн ур чадвар бүхий мэргэжилтэн, дасгалжуулагч, ажилтан хамт олны баг бүрдүүлж ажиллах.

Аймаг орон нутгийн түвшинд гарсан бодлого шийдвэрийг Биеийн тамир, спортын салбарт тулгуурлан боловсруулах, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах, спортын салбарт чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагуудтай хамтарч ажиллах.

Биеийн тамир, спорт нийтийн биеийн тамирын чиглэлээр ард иргэдийн оролцоог идэвхижүүлэх хэрэгцээтэй мэдээллээр хангах, салбарын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх

Орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй байгууллага хамт олон, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл өгөх, Аймгийн Биеийн тамир, спортын газрын өнөөгийн болон хэтийн хөгжилд нэн тэргүүнд анхаарч ажиллана.

БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Эрхэм зорилгыг хангахын тулд дараахь үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ.

Зарчим 1 - Байнга санаачлагч суралцагч хамт олон байх

Хамт олноороо шинэ санааг хүлээн авч дэмжин хөгжүүлэх хүсэл эрмэлзлэл дүүрэн байнгын тасралтгүй суралцагч болох ёстой

Зарчим 2 – Олон нийтэд үйлчлэх

Төрийн үйлчилгээний байгууллагын албан хаагч бүр иргэдэд үйлчлэх явдлыг өөрийн эрхэм үүргээ гэж үзэн, түүнийг хувийн ашиг сонирголоос ямагт дээгүүр тавих ёстой

3.3. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчин: Одоо ажиллаж буй ажилтнуудын мэдлэг мэргэжлийн түвшин:

Дарга 1: Дээд боловсролтой, Биеийн тамирын дасгалжуулагч багш, тухайн салбарт 3 жил ажилласан. Төрийн захиргааны Ахлах түшмэлийн тэргүүн зэрэгтэй.

Ахлах мэргэжилтэн 1: Дээд боловсролтой, Эрхзүйч мэргэжилтэй, спортын нэгдүгээр зэрэгтэй , улсад 18 жил тухайн салбарт 1 жил ажилласан туршлагатай.

Дасгалжуулагч: 4 Дээд боловсролтой тухайн салбарт 1-29 жил ажилласан туршлагатай.

Аймгийн Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 05-ны а/28 тоот Захирамжаар Биеийн тамир, спортын газрын бүтэц орон тоог 13 орон тоотой байхаар баталсан.

- 2016-2020 онд бүтэц орон тоог нэмэгдүүлж, 20 орон тоотойгоор ажиллана.

Биеийн тамир спортын газар нь жижүүр-2 үндэсний бөхийн дасгалжуулагч-1 үйлчлэгч-1 шинээр авч ажиллуулах.

	S -давуу тал	O-боломж
	<ul style="list-style-type: none"> ✓ Байгууллагын дарга Багш дасгалжуулагч мэргэжилтэй ✓ Биеийн тамир, спортын салбар болон аль нэг салбарт олон жил ажилласан туршлагатай мэргэшсэн ажилтнуудтай 	<ul style="list-style-type: none"> ✓ Орон нутгийн төр захиргааны байгууллагын дэмжлэг туслалцаа ✓ Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа ✓ Биеийн тамир, спорт, нийтийн биеийн тамир, сургалт дасгалжуулалтын

	<ul style="list-style-type: none"> ✓ Биеийн тамир, спортын салбарын хөгжил, орон нутгийн түвшинд хангах тогтолцоо бий болсон 	<p>асуудлаар мэргэшсэн баг ажилладаг</p> <ul style="list-style-type: none"> ✓ Бүх нийтийг хамарсан Биеийн тамир, спорт нийтийн биеийн тамирын арга хэмжээ, сургалт дасгалжуулалт, тэмцээн уралдааний үйл ажиллагаанд оролцох байгууллагын тоо, оролцоо нэмэгдсэн
	W- сул тал	Т-аюул занал
	<ul style="list-style-type: none"> ✓ Байгууллага батлагдсан орон тоо, нийтийг хамарсан арга хэмжээний салбарын үйл ажиллагааг явуулахад санхүүгийн нөөц дутмаг ✓ Сумдад Биеийн тамир, спортын чиглэлээр тусгайлан ажиллах орон тоо байхгүй 	<p>Үйл ажиллагаа явуулахад хүн хүч мөнгө санхүү дутмаг байдаг</p>

3.4. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Биеийн тамир, спортын газар нь хууль тогтоомжоор олгогдсон үндсэн чиг үүрэг, түүнд нийцүүлэн тодорхойлсон “ЭРХЭМ ЗОРИЛГОО” хэрэгжүүлэхэд чиглэгдсэн стратегийн зорилтоо дараах байдлаар томъёолж байна.

Стратегийн зорилт -1

Биеийн тамир спортын арга хэмжээг олон нийтэд хүргэх, хөгжүүлэх, эрүүл чийрэг, өв тэгш бие бялдартай, иргэн, тамирчдыг төрүүлэх

Стратегийн зорилт- 2

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллага, иргэд олон нийтийн оролцоо түншлэлийг бэхжүүлнэ.

Стратегийн зорилт-3

Үр дүнд суурилсан мэдээлэл, хяналт үнэлгээ, дотоод аудитын механизмыг боловсронгуй болгох.

Стратегийн зорилт-4

Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, манлайллыг хангаж, ил тод авилга хүнд сурталгүй үйлчилгээ, харилцааг төлөвшүүлэх.

3.5. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Биеийн тамир, спортын газар нь спортын талаар төрөөс баримталж байгаа бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлж, иргэдэд спортын үйлчилгээг хүргэх дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ .

- Биеийн тамир, спортын салбарын эрх ашгийг эрхэмлэн дээдлэх
- Спортоор хичээллэх иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ
- Спортоор хичээллэх тамирчдын бэлтгэл хийх, амжилт гаргах нөхцөл боломжийг хангасан орчинг бүрдүүлэх
- Спортоор хичээллэж байгаа хүүхдийн ээлтэй орчинг бүрдүүлэх
- Спортын салбарт иргэд олон нийтийн эрх тэгш идэвхитэй оролцоо тохиролцоонд үндэслэсэн хамтын ажиллагаатай байх


3.6. БАЙГУУЛЛАГЫН НЭН ТЭРГҮҮНД ХУДАЛДАН АВАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

/АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ТУС БҮРЭЭР/

Ажил үйлчилгээний анги	Ажил үйлчилгээний
Нэг: Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээний хүрээ, чанартай шуурхай үйлчилгээг өргөжүүлэх.	
1.1. Байгууллагын удирдлага, зохицуулалт	Төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж байгаа бодлогын зохицуулалт
	Төрийн албаны стандарт хангалт
	Салбарын байгууллагын хамтын ажиллагааны бодлого зохицуулалт
	Салбарын хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх
1.2. Байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод цахим хуудас ашиглан сурталчлах	Спорт сургалт дасгалжуулалтын ажил үйлчилгээ
	Спортын амжилт, сургалтын үйлчилгээ
	Нийтийн биеийн тамирын арга хэмжээ
	Байгууллага, сумдын биеийн тамир спортын хамтлаг
Хоёр: Биеийн тамир спортын нэгдсэн арга хэмжээг олон нийтийг хамруулан зохион байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх	
2.1. Нийтийг хамарсан спортын арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, нэгдсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Нийтийг хамарсан спортын нэгдсэн өдөрлөг арга хэмжээ зохион байгуулах
	Сургалт дасгалжуулалтын нэгдсэн сургалт зохион байгуулах
2.2. Улс, бүсийн, аймгийн чанартай спортын арга хэмжээнд тамирчид,	Спортын холбоод, байгууллагыг удирдлага арга зүйгээр хангах

албан байгууллага хувь хүмүүсийг идэвхитэй оролцуулах	Спортын үйл ажиллагааг дэмжих, хамтарч ажиллах
Гурав: Үр дүнд суурилсан мэдээлэл хяналт, үнэлгээ, дотоод аудитын механизмыг боловсронгуй болгох	
3.1. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийх	Сургалт сурталчилгаа
	Мэдээ, мэдээллийн үйлчилгээ

4. БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО, СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ГОЛ ЗОРИЛТ БУЮУ АЖИЛ ҮЙЧИЛГЭЭНИЙ АНГИЙН УЯЛДАА



Байгууллагын болон салбарын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж мэргэшсэн хүний нөөцөөр төрийн үйлчилгээг ард иргэдэд хүнд сурталгүй хүргэнэ.

ДӨРӨВ: ТУХАЙН ТӨСВИЙН ЖИЛД НИЙЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

4.1. ТУХАЙН ТӨСВИЙН ЖИЛД НИЙЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Удирдлага зохион байгууллат зохицуулалт гэсэн ажил үйлчилгээний хүрээнд дараах 3 арга хэмжээг нийлүүлнэ

Арга хэмжээ 1.1: Төрөөс спортын талаар баримталж буй бодлогын зохицуулалт

Тоо хэмжээ	Аймгийн Спортын “Цогц” хөтөлбөрийн баримт бичгийн хүрээнд спортын салбарын бодлогын баримт боловсруулах
	Спортын хөтөлбөр, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавиж хэрэгжүүлэх
	Засгийн газар, Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
	Дээд газрын тогтоол шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч, үндэсний хөтөлбөр, мөрийн хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлан ажиллах
	Аймгаас дэвшүүлсэн зорилго зорилт
Чанар	Тогтоол шийдвэрийг стандартын дагуу хяналтанд авч хэрэгжүүлэн тогтоосон хугацаанд тайлагнасан байна.
Хүн өдөр, өртөг	243 хүн өдөр
Хүрэх түвшин	Спортын холбогдолтой үндэсний хөтөлбөр тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайжирсан байна. Тогтоол шийдвэрийг салбарын онцлогт тохируулан үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Арга хэмжээ 1.2:Төрөөс Спортын талаар баримталж буй бодлогын зохицуулалт

“Уралдаан тэмцээн, ажил үйлчилгээ” гэсэн ажил үйлчилгээний хүрээнд дараах арга хэмжээг нийлүүлнэ.

Арга хэмжээ 2.1: Спортын үйл ажиллагаа удирдлага зохион байгуулалт

	Ард иргэдийг өргөн дэлгэр хамруулсан нийтийн биеийн тамирын арга хэмжээг удирдамж заавар хуваарийн дагуу зохион байгуулах
	Ард иргэдийн эрүүл мэндийн чанарт анхаарч өглөөний дасгал хөдөлгөөний арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулах

Тоо хэмжээ	Ард иргэд, сонгон суралцагчид, тамирчдын бие бялдрын түвшин тогтоох сорил авах, улсад мэдээлэл өгөх шивэлт хийх
	Аймгийн хэмжээнд бүх спортын тэмцээн уралдаан зохион байгуулах
	Спортын төрлүүдийн сургалт дасгалжуулалт тогтмол хичээллэх, тамирчдын амжилтыг ахиулах, зэрэгтэй тамирчин олноор төрөн гарах
	Биеийн тамир спортыг хөгжүүлэх аймгийн “цогц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
Чанар	Спорт, нийтийн биеийн тамирын үйл ажиллагаа тогтмолжсон байна Эрүүл чийрэг бие бялдартай иргэн нэмэгдсэн
Хүн өдөр, өртөг	177 хүн өдөр
Хүрэх түвшин	Спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх иргэдийн тоо нэмэгдэж, арга хэмжээнд оролцогчдын тоо өснө

“Салбарын үйл ажиллагаа” гэсэн үйл ажиллагааны хүрээнд дараах 1 арга хэмжээг нийлүүлнэ.

Арга хэмжээ 3.1: Салбарын нэгдсэн үйл ажиллагааны төлөвлөгөө

Тоо хэмжээ	Тухайн оны нэгдсэн төлөвлөгөө удирдамжын дагуу арга хэмжээ зохион байгуулсан байх
	Салбарын үйл ажиллагааг сурталчлах нэгдсэн цахим мэдээллийн хаягаа баяжуулах
	Тэмцээний уралдааны тайлан мэдээг нэгтгэх
Чанар	Биеийн тамир спортын бодлогын хэрэгжилт хангагдан ажиллана.
Хүн өдөр, өртөг	212 хүн өдөр
Хүрэх түвшин	Байгууллагын үйл ажиллагааны чанар хүртээмж дээшилнэ.

“Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх “ гэсэн үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг нийлүүлнэ.

Арга хэмжээ 4.1 Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт, арга зүйгээр хангах

Тоо хэмжээ	Жилд 1-2 удаа үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх
	Байгууллагын хяналт шалгалт, дотоод аудитын тухай сургалт зохион байгуулах
Чанар	Хяналт шалгалт хийгдэж, мэргэжил арга зүйгээр хангагдана.
Хүн өдөр, өртөг	32 хүн өдөр

Хүрэх түвшин	Байгууллагад хяналт шалгалт хийгдэж, арга зүйн мэдлэг мэдээлэлтэй болж, үйл ажиллагааны алдаа дутагдал илэрвэл түүний мөрөөр арга хэмжээ авна.
--------------	--

Арга хэмжээ 5.1 Спортын холбоод, нийтийн биеийн тамирын арга зүй, удирдлага арга зүйгээр хангах

Тоо хэмжээ	Орон тооны бус нийтийн биеийн тамирын арга зүйчдийг мэргэжил арга зүйгээр хангах сургалт зохион байгуулах
	Спортын холбоодыг арга зүйгээр хангах
Чанар	Нийтийн биеийн тамирын арга зүйчид болон спортын холбоод арга зүйгээр хангагдана.
Хүн өдөр, өртөг	32 хүн өдөр
Хүрэх түвшин	Нийтийн биеийн тамирын арга зүйч, спортын холбоод арга зүйгээр хангагдсанаар бие бялдрын түвшин тогтоох сорилын хувь нэмэгдэж, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээний тоо нэмэгдсэн байна.

“Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж мэргэшсэн хүний нөөцөөр төрийн үйчилгээг ард иргэдэд хүнд сурталгүй хүргэнэ” гэсэн үйл ажиллагааны хүрээнд дараах 1 арга хэмжээг нийлүүлнэ.

Арга хэмжээ 6.1 Байгууллагын үйл ажиллагааны талаархи мэдээллийг хэвлэл, мэдээлэл, олон нийтийн цахим хуудас ашиглан сурталчлах, ил тод нээлттэй байдлыг хангах

Тоо хэмжээ	Үйл ажиллагааны талаархи мэдээллийг олон нийтийн хэвлэл, цахим мэдээллийн хэрэгслээр сурталчлах
	Мэдээллийн самбар ашиглан үйл ажиллагааг сурталчлах
Чанар	Байгууллагын ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулна.
Хүн өдөр, өртөг	18 хүн өдөр
Хүрэх түвшин	Иргэдийн мэдлэг мэдээлэл сайжирна.

Арга хэмжээ 6.2 Байгууллагын материаллаг бааз бэхжүүлэх

Тоо хэмжээ	Спортын сургалт дасгалжуулалтын шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдах
	Мэргэжилтэн, дасгалжуулагчид ажилчдыг ажиллах тоног төхөөрөмжөөр хангах
Чанар	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх
Хүн өдөр, өртөг	46 хүн өдөр
Хүрэх түвшин	Ажиллах тав тухтай орчныг бүрдүүлсэн байх

4.2. ҮЙЛ АЖИЛЛАГААГ НИЙЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ


Биеийн тамир, спортын газар нь нийлүүлэх үйл ажиллагааны тоо, хэмжээ, чанарын бүх үзүүлэлтээр нийлүүлэхэд чиглэгдсэн дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Улс, аймаг, сумын хэмжээний төсвийн байгууллагууд болон өөр аймагийн спортын байгууллагуудтай хамтран ажиллана	Биеийн тамир спортын талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэгч болохын хувьд Монгол Улсын Засгийн Газар, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам, аймгийн ИТХурал, Засаг дарга, ЗДТГазрын НБХэлтэс, сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, сургууль цэцэрлэг болон бусад төрийн өмчийн болон төсвийн байгууллагуудтай удирдлага зохион байгуулалтаар хангагдах, зөвлөгөө мэдээлэл авах, тайлан мэдээ дамжуулах зэргээр байнгын харилцаа холбоотой байж хамтран ажиллана
Гадаад орон, олон улсын байгууллагатай түншлэлийн сайн харилцааг хөгжүүлнэ.	Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд шинэлэг арга барил соёл нэвтэрүүлэх, боловсон хүчнийг чадваржуулах, гадаад орны спортын салбараас суралцах, иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулан хөгжүүлэх чиглэлээр аль нэг улсын спортын байгууллагуудтай сайн түншлэлийн харилцаа тогтоож, гадаадын улс орны хандив тусламж, аймаг орон нутагт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд тэдгээртэй ажил төрлийн сайн харилцаа тогтоож, нягт хамтран ажиллана .
Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай түншлэлийн сайн харилцааг хөгжүүлнэ	Биеийн тамир спортын олон талт үйл ажиллагааг өргөжүүлэх, тэмдэглэлт баяр ёслол, арга хэмжээний хамрах хүрээ, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын материаллаг баазыг сайжруулахад аймаг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай түншлэлийн харилцаатай ажиллана.

4.3. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Биеийн тамир, спортын газар нь байгууллагын эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг ханган биелүүлэхэд чиглэсэн дараах зохион байгуулалтын хэлбэртэй байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛБЭРТЭЙ БАЙНА.



БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО

№	Албан тушаал	Тоо
Биеийн тамир спортын газар		
1	БТСГ-ын дарга	1

Байгууллагын стратеги/бизнес/ төлөвлөгөө

2	Ахлах мэргэжилтэн	1
3	Нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	1
4	Спорт тоглоом хариуцсан дасгалжуулагч	4
5	Нягтлан бодогч	1
6	Нярав архив бичиг хэргийн ажилтан	1
7	Үйлчилгээний ажилтан	5
Баруун бүсийн спорт хөгжлийн төв		
1	Арга зүйч	1
2	Заал зохион байгуулагч	1
Цэнгэлдэх хүрээлэн		
1	Сахиул жижүүр	1
Нийт-17		